



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/293

Номгон

Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээ зохион байгуулах зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 6.1.5 дахь заалтын задаргааны 3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах ажлын хүрээнд “Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн олимпиад”, “Хос бичигтэн байгууллага” арга хэмжээг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулсугай.

2.Энэхүү арга хэмжээнүүдийг зохион байгуулах удирдамж, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг), Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн аймгийн зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

3.Уг арга хэмжээний зардал болох 5.000.000 (Таван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний цахим, болон танхимаар сургалт, зөвлөгөөн зохион байгуулах зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь), Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг) нарт даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар
сарын 19 ний өдрийн 2/278 дугаар
захирамжийн хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН
МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗАРДАЛ

№	Зорилт, арга хэмжээний нэр	Хугацаа	Зардлын хэмжээ
1	2	3	4
1	Төрийн албан хаагчдын монгол бичгийн олимпиад зохион байгуулах	2023 оны 2, 3-р улирал	2,000,000
2	"Хос бичигтэн -төрийн байгууллага" шалгаруулах болзолт уралдаан зарлаж дүгнэх	2023 оны 2, 3-р улирал	3,000,000
Нийт төсөв (Таван сая төгрөг)			5.000.000

-----oOo-----